



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 128,470,344.25 (нэг зуун хорин найман сая дөрвөн зуун далан мянга гурван зуун дөчин дөрвөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 105,624,218.61 (нэг зуун таван сая зургаан зуун хорин дөрвөн мянга хоёр зуун арван найман төгрөг жаран нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 7 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Акталж, сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



000140

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн
153 дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Нийт гүйлт /мян.км/	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
1	УАЗ Фургон, 93-88 АРА, 374100В0452051	395.50	2011/2011	18,727,272.72	18,727,272.72	-	2,000,000.00
2	Хино кран, 62-38 АРА, GD3НКА10064	340.10	1990/2007	33,071,980.00	27,141,295.58	5,930,684.42	2,500,000.00
3	Ниссан Экстрайл, 22-26 ОРХ, NT30205443	361.19	2006/2014	19,900,000.00	10,060,555.36	9,839,444.64	5,000,000.00
4	УАЗ Фургон, 07-99 ОРХ, 374100304671-29	459.92	2007/2011	9,692,691.53	9,279,546.20	413,145.33	1,500,000.00
5	Тоёото пруйс 20, 93-67 ОРО, NHW200075913	338.28	2004/2012	14,000,000.00	13,689,122.29	310,877.71	1,500,000.00
6	УАЗ-2206, 25-09 ОРА, 000101250466329	550.00	2005/2005	18,078,400.00	16,309,759.84	1,768,640.16	800,000.00
7	Тоёота Хайлукс, 77-97 ОРО, RZN1859029888	405.00	1999/2013	15,000,000.00	10,416,666.62	4,583,333.38	2,300,000.00
				128,470,344.25	105,624,218.61	22,846,125.64	15,600,000.00
Нийт дүн				(нэг зуун хорин найман сая дөрвөн зуун далан мянга гурван зуун дөчин дөрвөн төгрөг хорин таван мөнгө)	(нэг зуун таван сая зургаан хорин дөрвөн мянга хоёр зуун арван найман төгрөг жаран нэгэн мөнгө)	(хорин хоёр сая найман зуун дөчин зургаан мянга нэг зуун хорин таван төгрөг жаран дөрвөн мөнгө)	(арван таван сая зургаан зуун мянга)